



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 0/453

Улаанбаатар хот

Монгол-Оросын хамтарсан ерөнхий
боловсролын сургуулийн балансаас
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэхь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгдчийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус дансанд бүртгэлтэй нийт 19,415,424 /арван есөн сая дөрвөн зуун арван таван мянга дөрвөн зуун хорин дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн балансад шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг холбогдох дансанд шилжүүлэн бүртгэхийг Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль /Ж.Соронзон/-д зөвшөөрсүгэй.


2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Баянгол дүүргийн 13 дугаар сургууль /С.Энхтуяа/-д үүрэг болгосугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Монгол-Оросын хамтарсан ерөнхий боловсролын сургууль /Ж.Соронзон/, Баянгол дүүргийн 13 дугаар сургууль /С.Энхтуяа/-д тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001245



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 13... сарын 13... өдрийн 13/04/19 дүгээр тушаалын хавсралт

Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллага: Монгол-Оросын хамтарсан сургуулиас Баянгол дүүргийн 13 дугаар сургуулийн сургуульд

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, Үзүүлэлт, хүчин чадал	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэх анхны үнэ				Хөрөнгө хүлээн авах байгууллага
						Нэгж үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн элэгдэл	Үлдэх хөрөнгө	
1	Сурагч сандал		2017	ш	248	35,532.5	8,812,060.0	1,835,845.8	6,976,214.3	Баянгол дүүргийн 13 дугаар сургууль
2	Сурагч ширээ		2017	ш	124	85,511.0	10,603,364.0	2,209,034.3	8,394,329.8	
Тавилга, эд хогшлын дүн							19,415,424.0	4,044,880.0	15,370,544.0	
Нийт							19,415,424.0	4,044,880.0	15,370,544.0	